

**“МОНГОЛЫН ГЕОЛОГИ, ХАЙГУУЛ-2022 ЧУУЛГА УУЛЗАЛТ”-Д ОРОЛЦОГЧДООС ИРҮҮЛСЭН САНАЛ
/2022.05.04-05.05/**

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажил	Хувийн хөрөнгөөр хийгдэж буй ажил	Геологийн бодлогын газар, ҮГА, АМГТГ
Сэдэвчилсэн геологийн судалгааг тухайлбал, гео-орчин, гидрогеологи, геоэкологийн судалгааг эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн болон их сургуулийн судлаачдаар хийлгэх шаардлагатай. Хувийн компани хийхээр ашиг харахаас биш, судалгааны гол ажилдаа төсөвөө зарцуулахгүй байна.	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын мэдээллийг илүү дэлгэрэнгүйгээр нийтэд статистик мэдээллийг хүргэх.	Геологийн алба геологийн судалгааны чиглэлийг тодорхойлдог гэж ойлгодог. Албаны албан хаагчдын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ГЗЕЭА-ын төслийн санхүүжилт байнга оройтдог.	Орон нутагтай хамтарч ажиллах, уялдаа холбоог сайжруулах.	Цахимаар мэдээлэл авах гэж албаны сайт руу хандахаар үргэлж гацаатай байдаг. Техникийн хүчин чадлыг сайжруулах хэрэгтэй.
Дээр үед хээрийн нэмэгдэл их хөшүүрэг болдог байсан. Одоо бараг байхгүйтэй адил. Геологичдоо жоохон харж хандаж хүндэлмээр байна. Шагнал урамшуулал бүр ч байхгүй.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэх, зарах зэргийн татварын ноогдлыг тодорхой болгох.	Геологичдын мэргэжлийг олон нийтийн ТВ-ээр эерэг талаар нь сурталчлах хэрэгтэй. Орон нутагт ажил хийх боломжгүй дарамттай байна.
Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж ажлын санхүүжилтийг хоцруулахгүй цаг тухайд нь олгож байхыг хүсэж байна. Санхүүжилт хийгдээгүйээ сүүлийн 3 сар цалингүй ажиллаж байгаа хүн байна.	Шинээр хөрөнгө оруулах сонирхолтой Аж ахуйн нэгжүүдэд сургалт, мэдээллийг түлхүү олгох.	Орон нутгийнханд Геологийн салбарыг таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх.
Улсын төсвөөр гүйцэтгэх ГХА-ыг тендерээр шалгаруулахдаа тус компанийн чадамжийг онцгойлон харгалзан үзэж байх. Тодруулбал тус компанид ажиллаж буй мэргэжилтний турглага, чадавхи, тоо хэмжээ, өрөмдлөг, геофизик, уулын ажил гүйцэтгэх тоног төхөөрөмжийн хангамж зэргийг харгалзах.	Хайгуулын ажил хийх нөхцөлийг бүрдүүлэх: -Нэгэнт олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хийж байгаа ажилд орон нутгийн оролцоог багасгах, шахалт дарамт, нам, улс төрийн чанартайгаар ажилд саад болж хувийн компаниудын үйл ажиллагаанд саад болохгүй баймаар байна. -Бүх бичиг баримт бүрэн, хуулийн хүрээнд хайгуул хийж байхад, орон нутаг саад болж	Төрийн байгууллагууд өөр хоорондынхоо харилцаагаа өргөжүүлж, нэг чиглэлд болгох.

	байвал сул зогссон болон бусад алдангийг орон нутгаас нөхөн төлүүлүүлэх, шалтгаангүй шантаанчлах, ажилд саад болохгүй байх гэж бодож байна.	
<p>Миний бие геологийн зураглалын салбарт ажилладаг. ҮГА-ны боловсон хүчнийг чадваржуулмаар байна. Мөн ЭБМЗ-ийн хуралд ҮГА-ны мэргэжилтнүүдийг суулгамаар байна. Учир нь тухайн үр дүнгийн тайланд засвар, зөвлөмж өгсөн мөртлөө огт хуралд нь суухгүй хариуцлага хүлээхгүй байна. Ядаж л би ийм засварыг ингэж, тэгж өгсөн гэж санал бодлоо оруулмаар байна. Үүнээс гадна мэргэжилтнүүдээ (ҮГА) өгөх О.Чулуун даргын санал, ажлын арга барилыг суулгамаар байна. Тэгэхгүй бол дарга, мэргэжилтэн 2 нь зарчмын хувьд зөрөөтэй бие биенээ үгүйсгэдэг байдал нь хүндрэлтэй байна. Дашрамд дурьдахад бид энэ мэргэжил ажилдаа үнэнхүү дуртай. Үүхийхээ төлөө ч тууштай явна. Үүний тулд санхүүжилтийг цаг тухайд нь өгч ажлаа харин авсан шиг авч бид ч харин өгсөн шиг өгье.</p>	<p>-ЭБМЗ-ийн хурлыг тогтмол хуралдуулах.</p> <p>-ЭБМЗ-ийн бүрэлдэхүүнийг шинээр томилох нь хэт ойрхон байгаа бөгөөд үүнээс болж хэдэн сараар хуралдахгүй Аж ахуйн нэгжүүдийн ажлыг хүлээлтийн байдалд оруулж байна.</p> <p>-ЭБМЗ-ийн даргыг геологийн салбарт туршлагатай хайгуулын ажлын онцлогыг мэддэг хүнээр томилох хэрэгтэй.</p> <p>-Тайлангийн тойрох хуудсыг цөөхөн хүнээр шалгуулах болсонд баярлалаа.</p>	<p>Төрийн ажилтнуудынхаа харилцаа дээр анхаарал тавих.</p>
<p>Монголын геологийн судалгаанд суурь ойлголт, нэр томъёог цэгцлэх асуудал үгүйлэгдэж байна. Нэгдсэн ойлголтоор явахгүй бол үйлдвэрлэлийн геологичдод нэлээд хүндрэл учирч байна.</p>	<p>Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд ажил хийхэд өргөн нутаг, ардууд хориг саад хийж байгааг дараах байдлаар шийдвэрлэх санал байна. Үүнд:</p> <p>1. Хайгуул хийж байгаа талбайн хэмжээ /га/-г тус сумын нутаг бэлчээрийн талбай /га/-тай харьцуулан ойлголт өгөх, хэвлэл мэдээллээр сурталчлах.</p> <p>2. Олборлолт, хайгуулын төлбөрөөс Улсын төсвөөр дамжиж тус суманд өгч буй санхүүжилт ба сумын мал аж ахуйн түүхий эдийн борлуулалтаас орж буй орлогыг хооронд нь харьцуулж сумын эрүүл мэнд,</p>	<p>ШУА-ийн Геологийн хүрээлэн нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн суурь судалгааг явуулдаг байгууллага бөгөөд суурь судалгааны төслийн санхүүжилтээ ШУТСангаас авдаг. Гол төлөв 30-35 сая төгрөгийг 3 жилд зарцуулдаг. Хэдий санхүүжилт бага ч судлаачид бид гадаад, дотоодын хамтын ажиллагааны шугамаар олон тооны шинэлэг мэдээллүүдийг би болгодог. Эдгээрийн дотроос цаашид нэмэлт судалгаа явуулах шаардлагатай ажлууд ахин төсөл үргэлжлүүлэх</p>

	боловсролд өгч буй санхүүжилтийн ач холбогдолыг ойлгуулж сурталчлах.	боломжгүй болж үлддэг. Иймээс УУХҮЯ, Геологийн бодлогын газраас геологийн суурь судалгаагаа дэмжиж Монголын Геологи судлалд бодитой хувь нэмэр оруулах боломжтой төслүүдийг санхүүжүүлдэг тогтолцоо бий болгож өгөхийг хүсэж байна.
Сэдэвчилсэн судалгааны төслүүдийг илүүтэй зарладаг болох тогтолцоо руу шилжж, үүнтэй зэрэгцэн шинжээч нарын чадавх дээр анхаарах.	Ашигт малтмалын нөөцийг программын аргаар бодсон нөөцийг дангаар хүлээж авах тал дээр анхаарч үзнэ үү.	Геологийн судалгааны явцад петрофизикийн судалгаа явуулж байх хэрэгтэй. Үүнийг бодлогоор зохицуулах шаардлагатай.
Орос, Америкийн геологийн хөгжил, улмаар Монголын геологийн голлох амжилт экспедиц ажиллаж хөгжсөн байдгийг анхаарна уу.	Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох аж ахуйн нэгжүүдэд тавих шаардлагаа өндөрсгөж, эхний 5 жилд шилжүүлэхийг хориглох.	Суурь судалгаа явуулдаг ШУА, Геологийн хүрээлэн нь үйлдвэрлэлийн геологиос тусдаа судалгаагаа явуулах хэрэгтэй. Нэгтгэх шаардлагагүй.
	Орон нутгийн шалтгаангүй эсэргүүцлийг төрийн зүгээс зөв мэдээллээр хангаж, ААН-үүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах.	Уулзалт, чуулга түлхүү зохион байгуулах.
УТХ-ийн судалгааны санхүүжилт цаг тухайдаа хийгдэхгүй удаж байгаагаас гүйцэтгэгч компаниуд хүнд байдалд орж байна. Санхүүжилтээ цаг тухайд нь өгдөг болмоор байна. Энэ жил төсвийн тодотгол маш их оройтож батлагдсан ҮГА-ны ажил цалгар байгааг анхаарах хэрэгтэй.	Шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсний дараа, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгодог байх тал дээр хуулийн орчин бүрдүүлэх. /Тусгай зөвшөөрөл авсны дараа АМтХ бол ТТАМтХ-д заагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэгт дурдсан холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүйн улмаас ААН, орон нутгийг, хяналтын байгууллагуудын дунд асуудлууд үүсч байна/.	Орон нутагт гарч байгаа хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэж, дараахь асуудлыг хуульд тусгах шаардлагатай. Үүнд: АМт хуулийг: <ul style="list-style-type: none"> • Геологи-ашигт малтмалын • Уурхайлахын /ордын/ • Кадастрын гэсэн бүлэгт хуваах юм уу тус бүрт нь ялгагдах хууль боловсруулах.
- Монгол Улсын хилийн бүсүүдэд гүйцэтгэж буй судалгааны ажлууд сайшаалтай. Иймээс цаашид үргэлжлүүлэн (сонгуулиас үл хамаарч), хилийн бүсийн геологи-ашигт малтмалын судалгааг гүйцээх. Хайгуул-судалгааны ажлаар өргөжүүлэх.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг орон нутаг болон мэргэжлийн хяналтын газраар хянуулдаг, батлуулдаг байдлыг зогсоох. Учир нь тухайн хянах ажлыг гүйцэтгэж байгаа албан тушаалтнууд нарийн мэргэжлийн хүмүүс	Хуулинд хэрэв нэгэнт хайгуулын зөвшөөрөл авсан тохиолдолд орон нутгаас захиргаа, хамт олон, хувь хүн үйл ажиллагаанд саад учруулж, хүндрүүлсэн тохиолдолд саад болсон хугацаа, үзүүлсэн хохиролуудад тохирсон торгууль ногдуулалт бүр их хүндрүүлсэн

<p>- ӨТ-түүхий эдийн судалгааг олон шат дарааллаар хийж байгаа нь сайшаалтай. Үүнтэй холбоотой хуулийн зарчим хоёрдмол болон ганцхан асуудлыг нэг мөр яаралтай шийдэх.</p>	<p>биш юм. Түүнчлэн тухайн хайгуулын төлөвлөгөө, тайлантай танилцахад өмнөх судлаачдын судалсан судалгааг л ашигласан байдаг учраас геологичид болон энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг илүү чадавхжуулж, орон нутагт энэ чиглэлээр тайлан, төлөвлөгөөг хянуулдаг байх шаардлагатай байна.</p>	<p>ноцтой нөхцөл бүрдвэл эрүү үүсгэдэг байх тухай тусгамаар байна. Өөрөөр хэлбэл засаг төрийн бодлого шийдвэрийг санаатайгаар эсэргүүцэж байгааг гэмт хэрэг хэмээн үзэх ёстой.</p>
	<p>Газрын ховор элементийн “хөөсөрсөн” байдлыг үнэнд нийцүүлэх, цаашид хөрөнгө оруулалт-шинэ сэргэлтийн бодлоготойгоо уях.</p>	<p>Геологи, хайгуул, уурхайлах, боловсруулах, гүн боловсруулахын үе шат, ач тусыг харуулсан ирезентаци бэлтгэж телевизийн сувгуудаар байнга цацах хэрэгтэй.</p>
	<p>Шар нунтаг, түүхий нефтийн асуудлыг Монгол Улсын эрх ашигт нийцсэн, Олон Улсын хэм хэмжээнд зөв бодлого үгүйлэгдэж байна. Ер нь бодлого боловсруулаад орхих биш түүнийг ажил хэрэг болгон зүтгэх хэрэгтэй байна. Цаг хугацаа, дэлхийн хөгжил Монгол Улсыг хүлээхгүй.</p>	<p>Бага бод, Их ажил, Бага ярь, Их хий.</p>
	<p>Нээлттэй эх мэдээллийг түгээх, мета-өгөгдөл стандарт.</p>	<p>Орон нутгийн асуудлыг зохицуулж өгөх.</p>
	<p>Тайлан хүлээж авах мэргэжлийн зөвлөлийг мэргэжлийн болгох.</p>	<p>Геологийн салбарын залгамж халаа алдагдахад хүрээд байна. Сүүлийн жилүүдэд Геологи, геофизик, гидрогеологи, инженер геологи, геоэкологийн мэргэжлээр суралцах оюутнуудыг бодлогоор дэмжих хэрэгтэй байна.</p>
	<p>Уул уурхайн салбар хэдийн өнөө цагт хамгийн үр өгөөжтэй хэдий ч нөгөө талдаа байгаль орчин, усны нөөц эргэн сэргээгдэхгүйгээр сүйтгэгдэж байна. Ус бол алтнаас ч үнэтэй, усгүй бол 1 хүн хэр удаан байж чадах вэ гэдгийг давхар бодолцдог байх шаардлагатай байна.</p>	<p>Залуу геологич нартаа ажилласан жилийг нь харгалзаад шагнал урамшуулалд хамруулж баймаар байна.</p>

	<p>Нөхөн сэргээгдээгүй орхигдсон уул уурхайн улмаас эвдэрсэн талбай, карьерыг бусад орны сайн туршлагаас үлгэрлэж (аялал жуулчлалын чиглэлээр ч юм уу ч хөгжүүлэх. Цахим орчинд орхигдсон, ашиглалтаас гарсан карьеруудыг зочид буудал шиг, цэцэрлэгт хүрээлэн шиг болгож хөгжүүлсэн бусад орны зурагнууд байдаг).</p>	<p>УУХҮЯ-ны ГБГ-т санал хүргүүлж байна. Үүнд: УУХҮЯ-ны ГБГ-аас гаргаж буй Геологийн хүрээлэн, Геологийн албаны газартай нэгтгэх асуудал нь байж боломгүй зүйл юм. Геологийн хүрээлэн нь ШУА-ийн харъяа газар бөгөөд эрдэм шинжилгээний ажлыг хийдэг стандарт арга аргачлалын дагуу судалгаа явуулдаг газар.</p>
		<p>Сүүлийн үед Монголын геологид дэвшилттэй судалгаанууд нэлээд хийгдэж байна. Гэвч үйлдвэрлэлд нэвтрэх байдал арай хожуу байна. Геологичдыг давтан сургахад анхаармаар байна. Дээр үед давтан сургах факультет ажилладаг байсан түүх бий.</p>
		<p>Яам болон газрын бодлого гэж тус тусдаа хараат улс шиг баймааргүй байна. Улсын хэмжээнд нэг бодлоготой, хоорондоо уялдаа холбоотой ажилламаар байна.</p>

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Геологийн бодлогын газар

2022.05.06